

МОНГОЛ-АНУ-ЫН ТҮНШЛЭЛ: ГУРАВДАГЧ ХӨРШ БАЙХЫН УЧИР

*ССХ-ийн Эрдэм шинжилгээний
Ахлах ажилтан Л.Бямбаханд*

Илтгэлийнхээ эхний хэсэгт Монгол Улсын оршин буй гадаад орчинд дүн шинжилгээ хийнэ. Дараа нь Монгол-АНУ-ын харилцааг товч дүгнэнэ.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүрээлэлд нь оршин буй гадаад орчин хурдтай өөрчлөгдөн, “тодорхойгүй байдал” олон улсын харилцааг нөмөрлөө. Үүний зэрэгцээ манай хоёр хөршийн бодлого чангарч, хөрш зэргэлдээ орнууддаа түрэмгий хандлага үзүүлэх боллоо. Хамгийн том илрэл нь ОХУ Крымыг 2014 онд өөртөө нэгтгэсэн явдал болов. Энэ үйлдэл нь ОХУ-ыг тойрсон зүүн европын жижиг улсуудыг айдаст автуулан, дараагийн “хохилогч” болохгүй байхыг эрмэлзэхэд хүргэсэн. Мөн ОХУ-ын шинэчлэгдсэн Аюулгүй байдлын стратеги¹ болон Гадаад бодлогын үзэл баримтлалд² тэргүүлэх чиглэл байсан Европын холбоо эрэмбэ буурч, ТУХН-ийн орнуудтай явуулах бодлогыг тэргүүлэх чиглэлд дурдагдсан байна. Нэн ялангуяа, Евро Азийн эдийн засгийн холбоог өргөжүүлэн тэлэхээр заажээ. Хэдийгээр ийнхүү хөрш орнууддаа анхаарал хандуулж буйн нь нааштай хандлага боловч нөгөө талаар, ЗХУ-ын үеийн хуучин нөлөөний бүсээ сэргээж, бүс нутгийн орнуудыг “тойрог зам”-даа оруулах гэсэн амбицыг нь илтгэж байна.

1 2015 оны 12 дугаар сард шинэчлэгдсэн

2 2016 оны 11 дугаар сард шинэчлэгдсэн

Энхтайванч өсөлтийг олонтоо тунхагласан Хятадын үнэн нүүр царай илэрч эхэллээ. Сүүлийн жилүүдэд Бээжингийн зүгээс Өмнөд Хятадын тэнгист хиймэл арлыг олноор байгуулах болсон. Маргаантай байдаг Спратлийн 8 арлын 7-д нь газар шинээр үүсгэсэн. 2015 оны 6 дугаар сарын байдлаар, 20 сарын хугацаанд 3000 акр хиймэл арал байгуулжээ. Энэ нь эдгээр арлын маргаанд оролцогч болох Вьетнам, Малайз, Филиппин, Тайвань зэрэг улсын 40 жилд барьж байгуулсан хиймэл арлаас 17 дахин их буюу Спратилийн арлуудад шинээр үүсгэсэн газрын 90 хувийг дангаар байгуулсан байна. Пентагоны 3 дугаар сард гаргасан илтгэлээс үзэхэд, дээрх хиймэл арлуудын хамгийн том 3 дээр нь тус бүрдээ 9800 фийт урттай нисэх зурвас бүхий хээрийн нисэх онгоцны буудал байгуулав. Мөн эдгээр хиймэл арлууд дээрээ Хятад байлдааны онгоц, хөлөг онгоц сөнөөгч пуужин, HQ-9 загварын газар-агаарын пуужин, хүчирхэг радаруудаа хэдийнээ байрлуулсан. Тухайлбал, Хайнань арлаас 600 милийн зайд орших Өмнөд Хятадын тэнгисийн маргаантай Квартерон шүрэн арлын орчим Хятадын байгуулсан 7 хиймэл арлын хамгийн урд талын арал дээр өндөр долгионы цэргийн радар байгуулсан. Энэ шинэ радар Хятадын хянах орон зайг нэмэгдүүлж, Малаккагийн хоолой хүртэлх байг сөнөөх боломжтой. Үүний зэрэгцээ цэргийн байгууламжуудынхаа тусламжтайгаар Хятадын хөлөг онгоцууд эх газар руугаа буцахгүйгээр Спратилийн арлын орчим удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэх боломжтой болж байна.

Хоёр хөршийн дээрх бодлого, үйл ажиллагаа Монгол Улсыг “Туравдагч хөрш”-ийн бодлого улам идэвхтэй хэрэгжүүлэхийг шаардаж байна. Монгол Улсыг “Туравдагч Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүд нь хөршүүдтэйгээ сайн харилцаатай байх, үүний зэрэгцээ “Туравдагч хөрш”-ийн хэмээн нэрлэгдсэн улс, холбоодтой улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршиж байна. Энэ хоёр бодлого харилцан нэгнийхээ дутууг гүйцээж нэгэн цогц бодлого болсноор Монгол Улсын аюулгүй байдал хангагдах учиртай.

1. Улс төрийн харилцаа:

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн урилгаар АНУ-д 2004 оны 7-р сард айлчлах үеэр “Монгол Улс, АНУ-ын Хамтарсан мэдэгдэл” дээд хэмжээнд гарч, хоёр талын харилцааг “стратегийн нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хүргэн хөгжүүлэхээр тохиролцсон нь хоёр талын харилцааг бүхий л салбарт идэвхжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлсэн. Монгол Улс, АНУ-ын харилцаа хамтын ажиллагаа сүүлийн 20 гаруй жилд бүхий л салбараар өргөжин хөгжиж байна.



Сүүлийн жилүүдэд хоёр талын өндөр дээд түвшний айлчлал тогтмолжиж, тэдгээрийн давтамж нэмэгдэж байна. Манай улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн болон бусад яамны сайд нар АНУ-д айлчилсан бол АНУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайд болон бусад төлөөлөгч манай улсад айлчилсан. Хамгийн сүүлд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри 2016 оны 6 дугаар сард Монгол Улсад айлчилсан нь хоёр талын харилцааны залгамж чанарыг хадгалахад ач холбогдолтой байв.

2. Эдийн засаг, худалдааны харилцаа:

АНУ нь Монгол Улсын гадаад худалдааны түнш орны нэг юм. 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол-АНУ-ын нийт бараа эргэлт 149,6 сая ам.доллар байна. Үүнээс импорт 93,05 хувь, экспорт 6,95 хувийг эзэлж байна. АНУ-тай хийсэн импортын худалдаа нийт импортын худалдааны 4,1 хувь буюу энэ үзүүлэлтээр АНУ 5-р байранд орж байна. Харин АНУ-тай хийсэн экспортын худалдаа нийт экспортын худалдааны 0,21 хувийг эзэлж байна. Монгол-АНУ-ын худалдаанд машин, техник, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн түгээмэл байна.³


Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд, гадаад худалдааны тухайд, импортын худалдаанд харьцангуй тэнцвэртэй бүтэц үүсчээ. Энэ нь импортын худалдаанаас манай улсад үүсэх эрсдлийг бууруулахад ач холбогдолтой. Цаашид манай улс бүтээгдэхүүн бүрд ханган нийлүүлэгч улсуудаа төрөлжүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

3 Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын мэдээ, 2017 он




Харин экспортын худалдаанд БНХАУ давамгайлсан байгаа нь манай эдийн засгийг нэг орны эдийн засгаас хамаарсан, мэдрэмтгий болгож, улмаар эдийн засгийн бие даасан байдлыг ихээхэн хязгаарлаж байна. Мөн энэ нь экспортын худалдаанд Монгол Улс “Туравдагч хөрш”-ийн сонирхлыг бий болгоход анхаарах шаардлагатайг давхар илтгэж байна.

Гадаад хөрөнгө оруулалт бол “Туравдагч хөрш”-ийн, тэр дундаа АНУ-ын эдийн засгийн бодит сонирхлыг бий болгож, уг сонирхлыг урт хугацаанд хадгалах гол хэрэгсэл юм. Графикаас харахад, 1990 оноос хойш Монгол Улсад бүртгэгдсэн нийт хөрөнгө оруулалтын талаас илүү хувийг Нидерланд, БНХАУ-ын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол АНУ-аас хийсэн хөрөнгө оруулалт нийт 2,16 хувийг эзэлж, тус улс Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 9-рт бичигдэж байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар 1990 оноос хойш АНУ-аас Монгол Улсад 308,2 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийсэн байна.



Монгол Улсад бүртгэгдсэн ГШХО-тай ААН-ийн тооноос үзэхэд АНУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нийт ГШХО-тай ААН-үүдийн 2,31 хувь болж, энэ үзүүлэлтээрээ 5-рт орж байна.



Дээрх статистик мэдээлэлээс дүгнэхэд, дэлхийн тэргүүлэх эдийн засаг болох энэ улсын боломж, бололцоог бид бүрэн ашиглаж чадаагүйг харуулж байна. Иймд хоёр талын эдийн засгийн харилцаа, түүний дотор АНУ-аас Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэхэд бид хамтран ажиллах шаардлага үүсч байна. Энэ зорилгоор манай улс хөрөнгө оруулалтын эрх зүйн орчноо тогтворжуулах, “Гуравдагч хөрш”-ийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих, эдийн засгийн олон талт механизмаар дамжуулан хоёр талын харилцааг институцлэх нь зүйтэй. Ийнхүү “Гуравдагч хөрш”-ийн бодит ашиг сонирхлыг бий болгосноор дан ганц нэг эдийн засгаас хамаарах хамаарлыг бууруулах төдийгүй эдийн засгийн бүтцээ төрөлжүүлэх боломж бүрдэнэ.

1. Боловсрол, шинжлэх ухааны харилцаа:


Хоёр тал соёл, боловсролын салбарт хамтран ажиллах тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт 1989 оны 9 дүгээр сард гарын үсэг зурсан. Уг хэлэлцээрийн хүрээнд холбогдох байгууллагуудын тохиролцоогоор 1990 оноос Монгол Улсад англи хэлний багш нар ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд монголын залуучууд гадаадын олон оронд суралцах болсны дотор АНУ-д суралцах оюутны тоо жил ирэх тутам нэмэгдэж байна. Манай зарим хувийн болон шашны байгууллагууд АНУ-д янз бүрийн хугацаагаар оюутан илгээж сургах ажлыг зохион байгуулдаг. Бүрэн бус мэдээгээр тэдгээрийн шугамаар 3900 гаруй

оюутан АНУ-д сурч байна.

Түүнчлэн, АНУ-ын олон нийтийн дунд манай улсын талаарх ойлголт нэмэгдэж, монгол судлал хөгжиж байна. Тухайлбал, АНУ-ын Индианагийн их сургуульд Монгол судлалын төв ажиллаж байгаа бол Калифорнийн Берклигийн их сургуульд монгол хэл, урлагийн талаарх хичээл америкийн оюутнуудад орж байна.

Сант марал сангийн сүүлийн 3-н жилд хийсэн судалгаагаар иргэд АНУ, Япон, БНСУ, Европын холбоог “Туравдагч хөрш”-ийн орнуудаас монголын чухал түнш гэж нэрлэсэн бөгөөд харин иргэдийн АНУ-ын талаар эерэг төсөөлөл харагдаж байна. Мөн АНУ-ын Галлоп агентлагийн Монгол Улсад хийсэн 3-н удаагийн судалгаагаар манай иргэд АНУ-ын манлайлалыг хүлээн зөвшөөрч буй байдал буурсан харагдаж байна.



Улс бие даасан, тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд дэлхийн бүх улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлэх гадаад бодлогын хүрээнд АНУ-тай хамтран ажиллахыг зорьж байна. Энэ чиглэлд хоёр тал улс төр, дипломат, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарт харилцах эхлэл хэдийнээ тавигджээ.

* * *

Л.Бямбахандын товч намтар:

Стратеги судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Ахлах ажилтан.

МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн баклавр, Унгарын Төв Европын Их сургуулийн олон улсын харилцааны магистр зэрэгтэй. АНУ-ын Ази, Номхон далайн аюулгүй байдлын төвд мэргэжил дээшлүүлсэн.

Тэрбээр АНУ-ын аюулгүй байдал, гадаад бодлого, Монгол-АНУ-ын харилцааны сэдвээр судалгаа хийдэг. АНУ-ын Ази, Номхон далайн бүс нутагт чиглэсэн “дахин тэнцвэржүүлэх” бодлого, АНУ-Хятадын харилцаа, АНУ-Оросын харилцаа зэрэг сэдвээр судалгааны өгүүлэл нийтлүүлж, эрдэм шинжилгээний хурлуудад оролцож байсан.

* * *